



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот


Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний
жагсаалт батлах тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Автотээврийн тухай” хуулийн 6 дугаар зүйл, “Төсвийн байгууллагад хийх бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолын 7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг “Нийслэлийн тээврийн газар”-т гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын 1, 2 дугаар хавсралтад заасан ажил, үйлчилгээний чиглэл тус бүрээр хоёр талын хулээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан гэрээ байгуулж (гэрээнд шилжүүлэн гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг зохион байгуулахад баримтлах заавар, аргачлалыг тусгах) ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан ажил, үйлчилгээг шуурхай зохион байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлagnаж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /П.Дэлгэрнаан/, “Нийслэлийн тээврийн газар” /Д.Отгонбаатар/-т тус тус үүрэг болгосугай.
3. Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний чанар, гүйцэтгэлийн байдалд жил тутам хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т даалгасугай.
4. Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний чанар, гүйцэтгэлийн байдалд жил тутам хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т даалгасугай.
5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг батлах тухай” Зам, тээврийн сайдын 2015 оны 163 дугаар тушаал, “Эрх олгох тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 31 дүгээр тушаал, “Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Зам, тээврийн сайдын 2013 оны 11 дүгээр тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Зам, тээврийн сайдын 2013 оны 158 дугаар тушаал,

2

“Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Зам, тээврийн сайдын 2015 оны 70 дугаар тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Зам, тээврийн сайдын 2015 оны 286 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны
11. дугаар сарын **09** нийн өдрийн **26** дугаар
 тушаалын нэгдүгээр хавсралт




“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т гэрээний үндсэн дээр шилжүүлэн
 гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалт

1. Улс, хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах
2. Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах
3. Шуудан тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах
4. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохион байгуулах
5. Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах
6. Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах
7. Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулах

----- оОо -----

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны
11 дугаар сарын 09 ны өдрийн 26 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



“Нийслэлийн тээврийн газар”-т гэрээний үндсэн дээр шилжүүлэн
гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалт

1. Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг
нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах

----- oOo -----